



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠒᠐᠒᠒ оны ᠐5 сарын 13 өдөр

Дугаар ᠕᠒88

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай” 211, 2020 оны “Зөвлөмж батлах тухай” 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ТӨБЗГ-2019/XI.1.57 дугаар гэрээт “Жишиг гудамж, тохижилт (Говь-Алтай)” ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- | | |
|-----------------|--|
| Комиссын дарга: | Г.Хурцгэрэл -(Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| Гишүүд | 3.Жаргалтуяа-(Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн) |
| | Н.Пүрэвдулам-(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн) |
| | Г.Мөнхөө -(Мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын улсын байцаагч) |
| | Д.Отгонжаргал-(Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч) |
| | М.Мандаххүү -(Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга) |
| | Ж.Дашдаваа -(Алтай хотын Цогц үйлчилгээний газрын дарга) |
| | М.Туул -(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн) |

2.

- Ц.Бат-Орших -(Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын дарга)
- Б.Түмэнбаяр -(Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, Цагдаагийн хошууч)
- Л.Ганхуяг -(Орон нутгийн өмчийн газрын өмчийн Газрын дарга)
- Л.Ганчулуун -("Гурван мөнх констракшн" ХХК-ийн ерөнхий инженер)

Нарийн бичгийн дарга:Б.Болд-Эрдэнэ-(“Бумбат даваа” ХХК-ийн захирал)

2.Барилга, байгууламж, тохижилтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч үр дүнг танилцуулахыг комисс (Г.Хурцгэрэл)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт болон холбогдох баримт бичгийг үндэслэн бүртгэж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, байгууламжийн урсгал засвар, үйл ажиллагааны зардалыг төсөвт тусгах, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  Д.АЛТАНЗАГАС

